# БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/145/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2026 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342716 Цахим хаяг: @audit.gov.mn

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

“Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит” ХХК-ийн захирал: С.Оргил
Утас: 99197346 Цахим хаяг: info@shinjlenmagadlakhui-audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 5-9
3. Аудитын тайлан ........................................................................................ 10-12
4. Аудитын илрүүлэлт ..................................................................................... 12-13
5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .................................................. **13**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn


2026.02.24 № 285

танай ________ ны № ________ т

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА Х.БАТХИШИГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Биеийн тамир, спортын газар нь аймгийн хэмжээнд спортын 13 төрлөөр 25 секц, дугуйлан тогтмол үйл ажиллагаа явуулж, 3,236 хүүхэд хамрагдан хичээллэж байгаа нь өмнөх оноос 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Биеийн тамир, спортын газрын дарга аймгийн Засаг даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7 хөтөлбөр, 22 арга хэмжээний хүрээнд

6326050415

85.6 хувиар үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д. БАТЦОГТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 114,048,629.00 | 87,570,146.80 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - |
| 33 | АВЛАГА | - | 1,220,867.80 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 1,220,867.80 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 114,048,629.00 | 86,349,279.00 |
| 351 | Түүхий эд материал | 5,043,200.00 | 1,885,200.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,960,000.00 | 1,410,000.00 |
| 35130 | Эм боох материал | 1,083,200.00 | 475,200.00 |
| 354 | Хангамжийн материал | 109,005,429.00 | 84,464,079.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 810,810.00 | 666,310.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 106,951,450.00 | 82,559,550.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 515,000.00 | 515,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 728,169.00 | 723,219.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,429,552,948.46 | 4,322,776,983.11 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,429,552,948.46 | 4,322,776,983.11 |
| 392 | Биет хөрөнгө | 4,332,930,948.46 | 4,226,154,983.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,800,431,330.68 | 4,800,431,330.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (664,856,944.81) | (755,748,462.13) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 73,600,000.00 | 73,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (37,119,999.81) | (44,479,999.77) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 153,642,283.00 | 164,556,283.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (69,887,910.41) | (97,584,382.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 67,959,090.38 | 83,289,090.38 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (36,796,428.61) | (43,867,023.07) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 45,749,561.20 | 45,749,561.20 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 190,226.00 | 190,226.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (20,259.16) | (21,640.48) |
| 39217 | Ном | 40,000.00 | 40,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 96,622,000.00 | 96,622,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,350,000.00) | (1,350,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 96,622,000.00 | 96,622,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,543,601,577.46 | 4,410,347,129.91 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 2,971,897.68 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 2,971,897.68 |
| 413 | Өглөг | - | 2,971,897.68 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 2,971,897.68 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,543,601,577.46 | 4,407,375,232.23 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,543,601,577.46 | 4,407,375,232.23 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,459,962,304.08 | 3,459,962,304.08 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,615,871,536.08 | 1,615,871,536.08 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 295,614,206.78 | 159,387,861.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 295,614,206.78 | 295,614,206.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (136,226,345.23) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 788,025,066.60 | 788,025,066.60 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,543,601,577.46 | 4,410,347,129.91 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,725,458,576.79 | 2,108,300,931.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 47,332,500.00 | 42,057,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 47,332,500.00 | 42,057,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 47,332,500.00 | 42,057,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 44,332,500.00 | 42,057,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,678,126,076.79 | 2,066,243,431.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 800,214,500.00 | 846,393,160.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 800,214,500.00 | 846,393,160.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 412,234,076.79 | 477,800,571.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 401,393,476.79 | 308,502,571.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,840,600.00 | 169,298,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 465,677,500.00 | 742,049,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 465,677,500.00 | 742,049,700.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,840,960,429.85 | 2,244,527,276.23 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,840,960,429.85 | 2,244,527,276.23 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,742,511,634.45 | 2,137,714,720.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 586,362,083.87 | 661,321,862.12 |
| 210101 | Үндсэн цалин | 371,898,635.75 | 381,996,968.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141,476,372.77 | 175,965,770.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,125,000.00 | 60,084,745.00 |
| 210104 | Урамшуулал | 37,862,075.35 | 43,274,379.12 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 72,569,203.60 | 79,798,034.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,444,858.75 | 56,008,471.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,029,937.98 | 6,081,112.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,913,030.04 | 3,143,493.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,631,135.38 | 2,912,982.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,550,241.45 | 11,651,975.12 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 464,484,410.13 | 760,021,597.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 30,691,494.53 | 41,166,237.73 |
| 210302 | Түлш, халаалт | 404,563,209.60 | 672,449,229.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 29,229,706.00 | 46,406,130.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,408,450.00 | 15,604,950.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,414,400.00 | 1,320,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,433,500.00 | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,506,800.00 | 1,759,750.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 588,600.00 | 932,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,252,000.00 | 2,486,950.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 11,213,150.00 | 8,305,350.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 28,879,329.92 | 20,717,679.92 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,096,759.92 | 1,145,959.92 |
| 210604 | Урсгал засвар | 21,782,570.00 | 19,571,720.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,452,500.00 | 1,133,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,452,500.00 | 1,133,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,934,752.00 | 4,342,313.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,365,320.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,020,200.00 | 1,752,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 162,000.00 | 143,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 156,100.00 | 185,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 165,132.00 | 196,013.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 560,420,904.93 | 594,774,683.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 426,381,484.00 | 464,400,678.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 134,039,420.93 | 130,374,005.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 98,448,795.40 | 106,812,556.08 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,929,899.00 | 58,752,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,145,927.00 | 57,752,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,037,972.00 | - |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,725,458,576.79 | 2,108,300,931.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 47,332,500.00 | 42,057,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 47,332,500.00 | 42,057,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 47,332,500.00 | 42,057,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 44,332,500.00 | 42,057,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,678,126,076.79 | 2,066,243,431.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 800,214,500.00 | 846,393,160.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 800,214,500.00 | 846,393,160.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 412,234,076.79 | 477,800,571.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 401,393,476.79 | 308,502,571.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,840,600.00 | 169,298,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 465,677,500.00 | 742,049,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 465,677,500.00 | 742,049,700.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,710,958,676.79 | 2,104,250,931.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,710,958,676.79 | 2,104,250,931.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,612,509,881.39 | 1,997,438,374.92 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 586,362,083.87 | 662,542,729.92 |
| 210101 | Үндсэн цалин | 371,898,635.75 | 383,217,855.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141,476,372.77 | 175,965,770.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,125,000.00 | 60,084,745.00 |
| 210104 | Урамшуулал | 37,862,075.35 | 43,274,359.92 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 71,922,731.39 | 79,798,034.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,824,056.54 | 56,008,531.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,029,937.98 | 6,081,112.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,913,032.04 | 3,143,493.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,631,135.38 | 2,912,982.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,524,569.45 | 11,651,916.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 464,484,410.13 | 757,049,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 30,691,494.53 | 41,166,237.73 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 404,563,209.60 | 672,449,229.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 29,229,706.00 | 43,434,232.32 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,139,600.00 | 7,299,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,177,200.00 | 1,320,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,433,500.00 | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,506,800.00 | 1,759,750.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 588,600.00 | 932,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,433,500.00 | 2,486,950.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,112,320.00 | 20,751,720.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,113,300.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 28,999,020.00 | 20,751,720.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,452,500.00 | 1,133,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,452,500.00 | 1,133,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,004,752.00 | 4,342,313.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,435,320.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,020,200.00 | 1,752,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 162,000.00 | 143,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 156,100.00 | 150,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 101,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 165,132.00 | 196,013.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 439,031,484.00 | 464,520,678.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 439,031,484.00 | 464,520,678.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 98,448,795.40 | 106,812,556.08 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,929,899.00 | 58,752,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,145,927.00 | 57,752,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,037,972.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,746,000.00 | 1,000,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 3,459,962,304.08 | 788,025,066.60 | 295,614,206.78 | 4,543,601,577.46 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (136,226,345.23) | (136,226,345.23) |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,459,962,304.08 | 788,025,066.60 | 159,387,861.55 | 4,407,375,232.23 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 841,712,307.00 | 1,582,757,227.92 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 841,712,307.00 | 1,578,707,227.92 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 840,712,307.00 | 1,519,954,927.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 308,253,100.00 | 608,672,198.92 |
| 210101 | Үндсэн цалин | 170,457,700.00 | 342,203,713.00 |
| 210102 | Нэмэгдэл | 90,558,000.00 | 163,109,381.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,663,000.00 | 60,084,745.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 13,574,400.00 | 43,274,359.92 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,505,707.00 | 73,390,658.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,447,700.00 | 49,601,155.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,089,200.00 | 6,081,112.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,567,200.00 | 3,143,493.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,432,807.00 | 2,912,982.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,968,800.00 | 11,651,916.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 411,146,900.00 | 757,049,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,250,000.00 | 41,166,237.73 |
| 210302 | Түлш, халаалт | 361,896,900.00 | 672,449,229.95 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,000,000.00 | 43,434,232.32 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,621,700.00 | 72,99,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 720,000.00 | 1,320,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 925,400.00 | 1,759,750.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 515,000.00 | 932,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,661,300.00 | 2,486,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,000,000.00 | 20,751,720.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,000,000.00 | 20,751,720.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,133,600.00 | 1,133,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,133,600.00 | 1,133,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,646,300.00 | 4,342,313.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,752,000.00 | 1,752,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 143,100.00 | 143,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,200.00 | 150,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 101,000.00 | 101,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 500,000.00 | 196,013.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,405,000.00 | 47,315,138.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,405,000.00 | 47,315,138.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 58,752,300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 58,752,300.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 57,752,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **4,050,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 4,050,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 4,050,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 1,630,500,360.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 846,393,160.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 846,393,160.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 742,049,700.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 742,049,700.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 42,057,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 42,057,500.00 |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Биеийн тамир спортын газарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Шинжлэн магадлахуй ЭЗШ Аудит ХХК-ийн аудитор С.Дарьсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Хоролбат, гүйцэтгэх захирал, аудитор С.Оргил нар тус тус хэрэгжүүлсэн.

2025 оны  санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг ДУНД гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлаас 1,710,958.68 мянган төгрөгийн 1.5  хувь 25,664.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 19,248.3 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэх үе  шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Булган аймгийн Биеийн тамир спортын газар нь тус хуулийн 15 дугаар зүйлд заасан арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан хэрэгжүүлж байгаа бөгөөд аудитаар хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

### 3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэр, орлого зарлага мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна

---

### 3.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 2 зөрчил илэрч, 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 2 зөрчил нь материаллаг бус зөрчил тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өгсөн болно.

### 4.1 Зөвлөмж

4.1.1 *Илрүүлэлт:* Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй, бараа материалыг сараар түүвэрлэн сарын сүүлчийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "Тасралтгүй байх зарчим", 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээ үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Цаг тухай бүрд нь орлого, зарлагын гүйлгээг программд оруулан шивж байх, санхүүгийн программыг бүрэн эзэмшиж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж өгөх

4.1.2 *Илрүүлэлт:* Жилийн эцсийн тооллогыг хийхдээ тооцоо бодсон акт байхгүй, бүртгэлийг хийгээгүй гараар бүртгэсэн хөтлөлттэй нь тооллогын чанартай үнэн зөв хийгээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "тасралтгүй байх" гэсэн зарчим, 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах зөвлөмж өгөх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа бараа материалыг сараар түүвэрлэн сарын сүүлчийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Жилийн эцсийн тооллогыг хийхдээ тооцоо бодсон акт байхгүй, бүртгэлийг хийгээгүй гараар бүртгэсэн хөтлөлттэй нь тооллогын чанартай үнэн зөв хийгээгүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **2** | **0** | | | | | **2** | **0** | | | | |